



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 12 сарын 25 өдөр

Дугаар 249

Улаанбаатар хот

Төсвийн хөрөнгө оруулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай

Төсвийн тухай хуулийн 10.1.7, 10.1.14, 43.1.3-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг төсвийн холбогдох ерөнхийлөн захирагч нарт даалгасугай:

1.1. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар баталсан Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2024 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн гүйцэтгэлийн явц байдалтай уялдуулан, төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцын дүнд багтаан хөрөнгийн зохицуулалт хийж, санхүүжүүлэх;

1.2. энэ тогтоолын 1.1-д заасан хөрөнгийн зохицуулалтыг Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулиар баталсан тухайн оны санхүүжилтийн дүнд багтаан 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн дотор төсөл, арга хэмжээ хооронд буцаан зохицуулалт хийж, санхүүжүүлэх;

1.3. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулиар санхүүжилт нь батлагдсан, гэрээ нь хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан, санхүүжилт бүрэн авах боломжгүй нөхцөл байдал үүссэн зарим төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн олгогдоогүй санхүүжилтийн үлдэгдлийг захиалагчийн барьцаа хөрөнгийн дансанд байршуулах;

1.4. төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн гүйцэтгэлд хяналт тавьж, баталгаажуулсны үндсэн дээр 2025 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн дотор энэ тогтоолын 1.3-т заасны дагуу барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан олгогдоогүй санхүүжилтийн үлдэгдлээс бодит гүйцэтгэлээр санхүүжүүлэх, тогтоосон хугацаанд чөлөөлөгдөөгүй үлдэгдэлтэй төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн гэрээг дүгнэж, эцсийн тооцоог баталгаажуулан улсын төсөвт төвлөрүүлэх;

1.5. Улсын Их Хурлаас соёрхон баталсан, Засгийн газар хоорондын гэрээгээр болон олон улсын байгууллагын хөнгөлөлттэй зээл, тусламжийн санхүүжилтээр хэрэгжүүлэх төслийн 2024 онд батлагдсан Монголын талын хөрөнгө болон гадаад төслийн зээлийн ашиглалтыг Сангийн сайдын барьцаа хөрөнгийн дансанд байршуулах;

1.6.Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах хүрээнд бүсчилсэн хөгжлийг дэмжих болон Нийслэл Улаанбаатар хотын дэд бүтцийн бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээний бэлтгэл ажил, зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах зориулалтаар 2024 оны батлагдсан санхүүжилтийн үлдэгдлийг төсвийн ерөнхийлөн захирагчийн хүсэлтэд үндэслэн захиалагчийн барьцаа хөрөнгийн дансанд байршуулах.

2.Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулиар Геологи хайгуул, судалгааны хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр хөрөнгийн зардалд батлагдсан санхүүжилтийн үлдэгдлийг Үндэсний геологийн албаны барьцаа хөрөнгийн дансанд байршуулж энэ тогтоолын 1.4-т заасны дагуу 2025 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн дотор бодит гүйцэтгэлээр чөлөөлж, зарцуулаагүй үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлэхийг Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваанд даалгасугай.

3.Санхүүжилтийн зохицуулалт хийх төсөл, арга хэмжээ болон барьцаа хөрөнгийн дансанд байршуулах санхүүжилтэд шалгуур үзүүлэлт гаргаж, түүний дагуу хяналт тавьж ажиллахыг Сангийн сайд Б.Жавхланд даалгасугай.



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

САНГИЙН САЙД

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

Б.ЖАВХЛАН